



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/42

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах хугацаанд Цэнхэрмандал сумын "Хэрлэн гүүр", "Дивизын гарам", Хэрлэн баян-Улаан тосгоны "Аягын гарам" зэрэг 3 цэгт 2021 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 17 хоногийн хугацаанд ажиллах 17 алба хаагчдын бичиг хэрэг, хоол, 3 автомашины шатах тослох материалын зардал болон аймгийн "Шуурхай штаб"-ын жижүүрт үүрэг гүйцэтгэж буй 5 алба хаагчдын бичиг хэрэг, хоолны зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэрлэн, Бор-Өндөр сумын "Төмөрт овоо", "Отволь", "М Ойл" цэгийн хяналтын 3 постонд үүрэг гүйцэтгэж буй 7 алба хаагчдын хоол, тээврийн хэрэгслийн шатахууны зардлыг Хэрлэн, Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар хариуцан зохион байгуулсугай.

3. Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллахад шаардагдах 10.230.560 /арван сая хоёр зуун гучин мянга таван зуун жар/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010121

Аймгийн Засаг даргын 2021 оны
...01... дугаар сарын 22 өдрийн .../12
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ			Дүн
	Бичиг хэргийн зардал	Шатахууны зардал	Хоолны зардал	
Цагдаагийн газар		1.560.600	5.780.000	7.340.600
Онцгой байдлын газар	200.000		1.700.000	1.900.000
Мэргэжлийн хяналтын газар	989.960			989.960
ДҮН	1.189.960	1.560.600	7.480.000	10.230.560